



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 5/18

Хэрлэн сум

Эрүүл мэндийн газрын дарга Л.Мэндбаярын  
хөдөлмөрийн гэрээг цуцалж,  
ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.1, 78 дугаар зүйлийн 78.1.4 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн 49 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн ХЭГ/595 дугаартай албан тоот бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Л.Мэндбаяр нь Төрийн албаны тухай хуульд заасан төрийн жинхэнэ албан хаагчид тавигдах шаардлагыг хангагүй албан тушаалд томилогдсон байх тул 2023 оны 5 дугаар сарын 03-ны өдрөөс хөдөлмөрийн гэрээг цуцалж, албан тушаалаас чөлөөлсүгэй.

2. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай

Комиссын дарга: Д.Өнөрцэцэг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Нарийн бичгийн  
Дарга: Ш.Эрдэнэжаргал Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захирагааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Гишүүн: Ж.Цэнджав Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Х.Доржханд Эмнэлгийн тусlamжийн хэлтсийн дарга

Ц.Алтан-Өлзий Аймгийн Эрүүл мэндийн газрын Нягтлан бодогч

Э.Майцэцэг Аймгийн Эрүүл мэндийн газрын Архив, албан хэрэг хариуцсан мэргэжилтэн

2.

3.Л.Мэндбаярын ажлыг зохих хууль журмын дагуу хүлээлцүүлэхийг Комиссын бүрэлдэхүүн (Д.Өнөрцэцэг)-т, холбогдох тооцоог хийж дуусгахыг аймгийн Эрүүл мэндийн газрын Нягтлан бодогч (Ц.Алтан-Өлзий)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

